



2018 оны 04 дүгээр сарын 09 ны өдөр



№ 18

Улаанбаатар хот

ХУДАЛДАХ, ХУДАЛДАН АВАХ ГЭРЭЭ

Энэхүү хамтран ажилах гэрээг нэг талаас "ЦЕГ-ын САНХҮҮ, АЖ АХУЙН АЛБА" /цаашид "Захиалагч" тал гэх/, нөгөө талаас "АРХАДЫН ХҮЧ ТББ"-ын дэргэдэх "АРХАД ПИКЧРЕС студи" /цаашид "Гүйцэтгэгч" тал гэх, хамтад нь "талууд" гэх/, нар Монгол Улсын Иргэний хуулийн 343-358 зүйлийг үндэслэн дараах нөхцөлөөр харилцан тохиролцож байгуулав.

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. **Гэрээний зүйл:** Энэхүү гэрээний дагуу гүйцэтгэгч нь захиалагчийн хүсэл сонирхолд нийцсэн бэлэг дурсгалын зориулалт бүхий арван тавны цагдаагийн морьтой 50 ширхэг баримал, 1 ширхэг нь 175 000₮ нийт 8,750,000 (найман сая долоон зуун тавин мянга) төгрөг, арван тавны цагдаагийн явган баримал 50 ширхэг баримал 1 ширхэг нь 155 000 ₮ нийт 7,750,000₮ (долоон сая долоон зуун тавин мянган) төгрөг нийт 100 ширхэг баримлыг 16,500,000 (арван зургаан сая таван зуун мянга) төгрөг тус тус гэрээнд заасан үнийн дүнд багтаан, холбогдох хууль тогтоомж, журам, стандарт, нормд заасан бусад нөхцөлийн дагуу хийж гүйцэтгэнэ.

1.2. **Гэрээний бүрдэл:** Дараах баримт бичгүүд нь гэрээний салшгүй хэсэг болно.

ХОЁР. АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ХУГАЦАА, ТАВИГДАХ ШААРДЛАГУУД

2.1. **Хугацаа:** Гүйцэтгэгч нь захиалагчийн ажлыг гэрээ байгуулагдсан өдрөөс эхлэн заасан хугацаанд бүрэн хийж гүйцэтгэсэн байна.

Гэрээ байгуулсан өдрөөс эхлэн үйлдвэрлэж хуанлийн 22 хоногийн дотор хийж гүйцэтгэнэ.

2.2. **Ажлын хамрах хүрээ:** Гүйцэтгэгч нь гэрээнд заагдсан баримлыг тоо ширхэг, хийц загварын дагуу гүйцэтгэнэ. Захиалагч өөрийн шаардлагаар гүйцэтгэх ажлын хамрах хүрээ, бусад баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулах тохиолдолд гүйцэтгэгч талд боломжит хугацаанд мэдэгдэнэ. Энэхүү нэмэлт, өөрчлөлт нь нэмэлт төлбөр, хугацаа шаардагдах бол гүйцэтгэгч энэ тухай захиалагч талд ажлын 2 хоногт мэдэгдэж нэмэлт өөрчлөлт оруулна.

2.3. **Чанар:** Гэрээт ажил нь захиалагчийн шаардлагын дагуу батлагдсан загварын хүрээнд мэргэжлийн өндөр түвшинд гүйцэтгэгдсэн байх ёстой бөгөөд

худалдан авалтын бодлогыг зөрчсөн гэж үзэж, энэхүү гэрээг нэг талын санаачилгаар цуцалж, учирсан хохирол зардлаа шаардах, гүйцэтгэгчид үүсэх үр дагаврын талаар ямар нэгэн хариуцлага хүлээхгүй байх эрхтэй.

АРВАН ХОЁР. БУСАД ЗҮЙЛ

12.1. **Гэрээ хүчин төгөлдөр болох:** Гэрээ нь талуудын эрх бүхий төлөөлөгчид гарын үсэг зурж, тэмдэг дарснаар хүчин төгөлдөр болж, гэрээг хугацаанаас нь өмнө цуцалснаар буюу гэрээний нөхцөл бүрэн биелэгдсэнээр дуусгавар болно. Талууд гэрээ дуусгавар болгохтой холбоотойгоор гэрээг дүгнэсэн акт үйлдэж болно.

12.2. **Нэмэлт, өөрчлөлт:** Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг талууд харилцан тохиролцож, нэмэлт гэрээ байгуулсны үндсэн дээр шийдвэрлэнэ. Аль нэг тал гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах саналаа нөгөө талд бичгээр хүргүүлэх бөгөөд саналыг хүлээн авсан тал ажлын 2 хоногийн дотор хариу мэдэгдэх үүрэг хүлээнэ.

12.3. **Санал, хүсэлт:** Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах санал, гэрээг дуусгавар болгох, хугацаанаас нь өмнө цуцлах тухай мэдэгдэл болон гэрээтэй холбогдон нэг талаас нөгөө талдаа гаргаж буй аливаа санал, мэдэгдэл, хүсэлтийг бичгээр үйлдэж 3-аас доошгүй хоногийн өмнө нөгөө талдаа гэрээнд заасан хаягаар баталгаат шуудангаар эсвэл биечлэн хүргүүлснийг хүчинтэйд тооцно.

12.4. **Гэрээний эх хувь:** Гэрээг гурван хувь үйлдэж, талууд тус бүр нэг хувийг хадгалсан нь хууль зүйн хувьд адил хүчинтэй.

12.5. **Өмнөх тохиролцоо:** Энэхүү гэрээг байгуулахаас өмнөх аливаа аман болон бичгэн тохиролцоо энэхүү Гэрээг байгуулснаар хүчин төгөлдөр бус болно.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТАЛУУДЫГ ТӨЛӨӨЛЖ:

"ГҮЙЦЭТГЭГЧ" талыг төлөөлж:

"АРХАДЫН ХҮЧ" ТББ-ЫН ЗАХИРАЛ


Л.ГАН-ОД

Хаяг: БГД-ийн 4-р хороо, нарны 20 – ын

Г4-байр 4 давхар 17 тоот

Утас: 99114668, 98986398

Е-мэйл: arkhadpictures@gmail.com

"ЗАХИАЛАГЧ" ТАЛЫГ ТӨЛӨӨЛЖ:

ЦЕГ-ЫН СААА-НЫ ХАНГАМЖИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА, ЦАГДААГИЙН
ХУРАНДАА


С.БААСАНЖАВ

МӨН АЛБАНЫ ХАНГАМЖИЙН
ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН,
ЦАГДААГИЙН ДЭСЛЭГЧ


Д.ГАН-ЭРДЭНЭ

Хаяг: Чингэлтэй дүүргийн 4-р хороо

Утас: 70114412

Факс: 70115817

Харилцагч банк : Төв төрийн сан банк